ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 22 өдөр Дугаар 22 Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед авах хариу арга хэмжээг эрчимжүүлэх, халдвараар өвчилсөн даатгуулагчид үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх зорилгоор Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.2, 14.8.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн "Журам батлах тухай" 2018 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 05 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн хөрөнгийг тооцох, зарцуулах, банкинд хадгалуулах журам"-ын 4 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 4.8 дахь хэсэг нэмсүгэй:

"4.8. халдварт цар тахлын тархалтын эсрэг хариу арга хэмжээний зардлыг эрсдэлийн сангаас санхүүжүүлэхэд энэ журмын 4.5-д заасныг баримтлахгүй байж болно. "

2. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн "Журам батлах тухай" 2018 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 05 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн хөрөнгийг тооцох, зарцуулах, банкинд хадгалуулах журам"-ын 4.2.2 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"4.2.2. хүн амыг олноор хамарч удаан хугацааны эмчилгээ, зардал шаардагдах өвчин, халдварт цар тахлын тархалтыг таслан зогсооход шаардлагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуур, багаж, тоног төхөөрөмжийн зардлыг санхүүжүүлэх"

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба /Л.Номин/-нд даалгасугай.

ДАРГА Т.МӨНХСАЙХАН